



Дундговь аймгийн Өлзийт суманд 1992-2016 онд ИТХ-ын дарга, нарийн бичгийн даргаар ажиллаж байсан хүмүүсийн товч намтар, ажлын амжилт

1992-1996 он



Бариад овогтой Нарантуяа 1960 онд Өлзийт суманд төрсөн. Төсвийн нягтлан бодогч мэргэжилтэй. Санхүү, татвар, банкны системд улсад 34 жил ажилласан. Санхүүгийн техникум төгссөн.

1980-1986 онд Өлзийт сумын АДХГЗ-ны Санхүү тасагт ня-бо, 1986-1991 онд Санхүү тасгийн дарга, 1991-2011 онд сумын татварын байцаагч, 2011-2013 онд Хадгаламж банкны Өлзийт сум дахь салбарын эрхлэгч хийж байсан. Ардын хувьсгалын 70, 80, 90 жил, Их монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, Сангийн Яамны 100 жилийн ойн хүндэт тэмдэг, "Санхүү банкны тэргүүний ажилтан" цол тэмдэг, Татварын албаны "Хүндэт тэмдэг", Сангийн Яамны жуух бичиг, 2017 онд "Нутгийн удирдлагын тэргүүний ажилтан"-аар шагнагдсан. 1992-1996 онд Өлзийт сумын ИТХ-ын орон тооны бус даргаар ажилласан..



Хандсүрэн овогтой Бямбаа 1944 онд Өлзийт сумын нутаг "Цэцийн хар" хэмээх газар төрсөн. Бага, дунд сургууль, жолооч, гагнуурчны дамжаанд суралцан жолооч, гагнуурчны мэргэжил эзэмшсэн. 1966 онд цэргийн албанд татагдан Өмнөговь аймгийн Овоотын отрядад 3 жил алба хаасан. Х.Бямбаа цэргээс халагдаж ирээд 1969-1970 онд МАА-н бригадын тоо бүртгэгч, 1970-1977 онд Өлзийт, Хулд сумдын ХЗЭ-ийн үүрийн нарийн бичгийн дарга, 1977-1987 онд Хулд сум нэгдэлд жолооч, 1987-1993 онд Өлзийт сумын "2-р таван жил" нэгдэлд жолооч, гагнуурчин, автын механик, 1995-2000 онд Өлзийт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, 2000-2004 онд сумын ЗДТГ-т түшмэл, Тамгын газрын даргаар ажиллаж байгаад гавъяаны амралтаа авчээ. Ардын хувьсгалын 70, 80, 90 жилийн ойн медаль, Их монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, МХЗЭ-ийн 50 жилийн ойн медаль, Эвлэлийн Төв Хорооны Хүндэт үнэмлэх, "Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч тэргүүний ажилтан" цол тэмдэг, Монголын бүх ард түмний урлагийн үзлэгийн Хүрэл медаль, "Монгол улсын тэргүүний уран сайханч" цол тэмдэг, VI, VII таван жилийн гавшгайч цол тэмдэг зэргээр шагнасан байна.

Энэ хугацаанд тухайн хурлын дарга, нарийн бичгийн дарга нар шинэ байгуулагдсан НӨУЁ-ны байгууллагын үйл ажиллагааг тогтмолжуулах, төлөвшүүлэхэд голчлон анхаарсан. Тухайлбал: Төлөөлөгч, тэргүүлэгчдийн идэвхийг нэмэгдүүлэх, сонгогчдын санал, хүсэлтийг хурлаас гарах шийдвэрт тусгуулах, БИНХ-ын ирцийг хангуулах, БИНХ-ын даргын хийсэн ажлыг иргэдэд



танилцуулах,Төсөвт байгууллагын дарга нарын сонголыг хэлэлцэх, сумын төсвийн орлого, зарлагыг хэлэлцэж батлах, боловсон хүчний асуудалд анхаарах, хууль тогтоомжийг сурталчилах, Засаг даргатай хамтарч ажиллах зэрэг ажлыг хийжээ.

1996-2000 он



Н.Цэвэгмэд 1944 онд Өлзийт сумын нутаг “Дэл” хэмээх газар төрсөн.Бага сургууль төгсөөд мал аж ахуй дээр ажиллаж байгаад 1959 оноос тус сумын “2-р Таван жил” нэгдлийн туслах үйлдвэрт ажилчин болсон.1960-1962 онд сумын Худалдаа бэлтгэлийн ангид манаач, 1962-1964 онд сумын Мал эмнэлэгт санитарч, 1964-1965 онд ХБ ангийн тоо бүртгэгч, мөнгөний нярав, 1965-1968 онд Худалдаа бэлтгэлийн ангийн дарга, 1968-1996 онд сумын АДХГЗ-ны орлогч дарга, 1996-2000 онд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга хийж байсан. Алтан гадас” одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, Ардын хувьсгалын 60,70,80 жил, Ардчилсан хувьсгалын 20 жил, Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, ”Бүртгэл-статистикын тэргүүний ажилтан” цол тэмдэг, VI таван жилийн гавшгайц цол тэмдэг, Ардчилсан намын дээд шагнал “Эрх чөлөөны одон” Үндэсний шинэ намын “Цагаан шонхор” медиал, 2017 онд “Нутгийн удирдлагын тэргүүний ажилтан”-аар шагнагдсан.

Энэ хугацаанд нарийн бичгийн даргаар Х.Бямбаа ажиллаж байсан бөгөөд хурлын дарга, ажлын албанаас БИНХ-ыг үр дүнтэй хуралдуулах, хуралд оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ЗЗНДНТУХ-ийг сурталчилах, иргэдэд ойлгуулах, Засаг даргатай хамтарч ажиллахад ажлаа чиглүүлэн ажиллаж байсан.

2000-2004 он



Д.Баярсайхан 1954 онд Дундговь аймгийн Сайнцагаан сумын төрөхд мэндэлжээ.Дунд сургууль, ХАА-н техникум,ХААДС-ийг дүүргэж мал зүйч,малын их эмч мэргэжил эзэмшсэн. 1973-1974 онд Цагаандэлгэр суманд малзүйч, 1974-1977 онд цэргийн алба, 1977-1984 онд Сайнцагаан сумын ХЗЭ-ийн үүрийн нарийн бичгийн дарга,Аймгийн ХЗЭ-ийн Хороонд зааварлагч, 1984 онд Өлзийт суманд малын их эмч,2000-2004онд Өлзийт сумын Иргэдийн Төлөөлөгчийн хурлын дарга, 2004 оноос одоог хүртэл “Өлзийт өнт” хувьцаат компаны Захирлаар ажиллаж байна. Ардын хувьсгалын 70,80,90 жилийн ойн медаль, ”Хүнс-ХАА-н тэргүүний ажилтан” цол тэмдэг, 2015 онд Алтан гадас одон, 2017 онд “Нутгийн удирдлагын тэргүүний ажилтан”-аар шагнагдсан.



Б.Хорлоо 1972 онд Өлзийт сумын төрөхөд төрсөн.бага дунд сургууль, Удирдлагын академийг төгссөн. Удирдлагын менежер мэргэжил эзэмшсэн.2004-2007 онд сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, 2008 оноос одоог хүртэл сумын ЗДТГ-ын даргаар ажиллаж байна. Хөдөлмөрийн хүндэт медаль, Засгийн Газрын Жуух бичиг, 2012 онд Аймгийн “Шилдэг менежер” цол өргөмжлөл, 2017 онд “Нутгийн удирдлагын тэргүүний ажилтан”-аар шагнагдсан.

Сонгуулийн хугацаанд ИТХ-аас Иргэдийн төлөөлөгчдийн чадавхийг нэмэгдүүлэх, сумын төсөвт орох орлогыг бодитой тогтоож гүйцэтгэлийг хангуулах, ажлын албаны ажлын байрны нөхцлийг сайжруулах, ажлын албаны ажилтны мэргэжил, боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ажилласан байна.

2004-2012 он



Ч.Цэцгээ 1957 онд Өлзийт сумын төрөхөд төрсөн.Малын их эмч мэргэжилтэй.1974-1976 онд малчин,1976-1982 онд ХАА-н Дээд сургууль, 1982-1989 онд Дундговь аймгийн Хулд суманд малын их эмч,1989-1994 онд Өлзийт суманд малын их эмч,1994-1997 онд мөн суманд нийгмийн даатгалд байцаагч,1997-2004 онд сумын хөдөлмөр, халамж хариуцсан мэргэжилтэн, 2004-2012 онуудад тус сумын ИТХ-ын дарга,2012 оноос “Ембүүт булаг” ХХК-ны захиралаар ажиллаж байна. 1976 онд МХЗЭ-ийн Төв Хорооны шагнал “Тэргүүний малчин залуу”

алтан медаль, 1990 онд 8-р таван жилийн гавшгайч, 1991онд МХЗЭ-ийн Төв Хорооны“Тэргүүний малчин залуу” алтан медаль, 2005 онд МУЗН-ийн хүндэт тэмдэг,Нигүүсэл мөнгөн медаль, 2007 онд Их Монгол улсын 800 жилийн ойн медаль, ХАА-н Тэргүүний ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медаль, 2008 онд Алтангадас одон, 2017 онд “Нутгийн удирдлагын тэргүүний ажилтан”-аар шагнагдсан.



Довчиншарав Төмөртогтох 1977 онд Дундговь аймгийн Мандалговь хотод төрсөн. 1995 онд Мандалговь хотын 3-р 10 жилийн сургууль ,1997-2001 онд Их Засаг Их сургуулийг төгссөн. Эрх зүйч мэргэжилтэй. 2001-2004 онд аймгийн Засаг даргын хуулийн зөвлөх,2004-2008 онд Гурвансайхан сумын ЗДТГ-ын дарга, 2009-2012 онд Өлзийт сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга,2013-2016 онд Гурвансайхан сумын Засаг даргаар ажиллаж байна.



2004 онд Залуучуудын холбооны “Тэргүүний залуу” алтан медаль, 2010 онд аймгийн хүндэт тэмдэг, Засаг даргын жуух бичиг, 2017 онд “Нутгийн удирдлагын тэргүүний ажилтан”-аар шагнагдсан.

ИТХ-ын дарга, ажлын албанаас ажиллах хугацаандаа сумын эдийн засаг нийгмийг 2009-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулан батлуулж мөрдөх, нутгийн удирдлагын холбоотой хамтран төлөөлөгчдийн боловсролыг дээшлүүлэх, Нутгийн зөвлөл болон бусад төрийн бус багууллагын дэмжлэгтэйгээр залуучууд, эмэгтэйчүүдийн чуулга уулзалт зохион байгуулах, Швейцарын хөрөнгө оруулалттай “ногоон алт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг томоохон ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

2012- оноос



Х.Отгонмөнх 1982 онд Өлзийт сумын төрхөд төрсөн.

Математик-Мэдээлэл зүйн багш мэргэжил эзэмшсэн. 2003-2007 онд “Мөнх тэнгэр”, “Хан-Уул” дээд сургууль төгссөн. 2007-2012 онд Дундговь аймгийн Өлзийт сумын ерөнхий боловсролын дунд сургуулийн захирал, 2012 оноос тус сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргаар ажиллаж байна. БСШУЯ-ны Хүндэт жуух бичиг, Монголын багш нарын холбооны шагнал “Алтан эрдэнэ” медаль, Боловсролын байгууллагын 90 жилийн ойн медаль, МЗХ-ны “Тэргүүний залуу” алтан медаль, Залуучуудын байгууллагын 90 жилийн ойн медалиар шагнагдсан.



Ж.Наранжав 1962 онд Говь-Алтай аймгийн Цээл суманд төрсөн. Гидротехникч инженер, төрийн удирдлагын зохион байгуулалт мэргэжилтэй. 1981 онд Говь-Алтай аймгийн 1-р 10-н жил, 1986 онд Польшын Дээд сургууль, 1994-1996 онд Төрийн захиргаа, Удирдлагын хөгжлийн Институтийг төгссөн. 1986-1987 онд Дундговь аймгийн УААУГ-ын ус ашиглалт, хамгаалалтын улсын байцаагч, 1987-1988 онд аймгийн АДХГЗ-ны ХАА-г Удирдах Газарт ус ашиглалт хамгаалалтын улсын байцаагч, 1988-1992 онд аймгийн Байгаль орныг хамгаалах газарт Байгаль орчны улсын ахлах байцаагч, 1992-1997 онд аймгийн ЗДТГ-ын Байгаль орчны хэлтсийн дарга, газрын асуудал хариуцсан түшмэл, 1997-2003 онд аймгийн Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн товчооны Улсын бүртгэгч, 2006-2013 онд Өлзийт сумын ЗДТГ-ын Газрын даамал-Байгаль орчны улсын байцаагч, 2013 оны 9-р сараас сумын ИТХ-ын нарийн бичгийн даргаар ажиллаж байна. 1991 онд Монголын Залуучуудын Холбооны “Тэргүүний сэхээтэн залуу”



алтан медаль, 2010 онд Байгаль орчны Яамны жуух бичиг, 2012 онд Ардчилсан намын дээд шагнал “Эрх чөлөөний одон”, 2013 онд Аймгийн Засаг даргын Жуух бичиг, 2014 онд Байгаль орчны тэргүүний ажилтан цол, тэмдэг, 2017 онд “Алтангадас” одонгоор шагнагдсан.

ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нар нь энэ хугацаанд дараахь ажлыг хийж гүйцэтгэжээ.

Орон нутгийн тусгай хамгаалалтанд 6 байршилд нийт **919271,67** га газрыг авсан нь сумын нийт нутаг дэвсгэрийн **59.6** хувийг эзэлж байна. Энэ нь замбараагүй лиценз олголт, дээж авах нэрийдлээр ашигт малтмал олборлох явдлаас урьдчилан сэргийлж, даац хэтэрсэн бэлчээрээ хамгаалах арга хэмжээ юм.

Суманд ОНХС-ийн хөрөнгө буй болсонтой холбогдуулан иргэдээс ирсэн саналыг орон нутгийн бодлоготой уялдуулах, ОНХС, Сум хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэх сангийн үйл ажиллагааг давхардуулалгүй зөв зохистой, харилцан уялдаатай явуулах, 2009 онд батлагдсан сумын “нийгэм, эдийн засгийн 2009-2020 оны хөгжлийн төлөвлөгөө”-нд үнэлгээ хийж шинэчлэн боловсруулах ажлыг иргэд, ТББ, мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор хийж гүйцэтгэсэн.

“Хил хязгааргүй алхам” ТББ, сумын иргэд, олон нийтийн байгууллагын оролцоотойгоор сумын байгаль орчны одоогийн төлөв байдлын суурь судалгааг гаргаж “2016-2021 оны сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө” боловсруулж ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж эхэлсэн.

Суманд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн ААН, сумын ЗДТГ, иргэдийн төлөөлөл оролцсон “Уул уурхайн ил тод байдал” гурвалсан хэлэлцүүлгийг жил бүр тогтмол зохион байгуулж байна. Хэлэлцүүлгийн үр дүнд өгсөн авсан хандив тусламж, татвар, төлбөрийг ил тод тайлагнаж байгаа нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх ач холбогдолтой.

НҮБХХ-ийн “Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл”-ийн нэгжээс зарласан тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд “Уул уурхай дахь ИТХ-ын хяналт” 4 сая төгрөгний төслийг хэрэгжүүлсний үр дүнд “Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ААН, байгууллагад ИТХ-аас тавих хяналт, үнэлгээний журам”-ыг батлан мөрдөж байна.